

**МОНГОЛЫН УДИРДЛАГА БОЛОН КОМИНТЕРНЫ ХАРИЛЦААГ
ХУРЦАТГАСАН НЭГЭН ТОГТООЛЫН
ТАЛААР ЭРГЭЦҮҮЛЭХЭД**

Д.Дашдулам

Ph.D. МУИС, НШУС, Түүхийн тэнхимийн багш

Өгүүллийн товч утга: Энэхүү өгүүлэгтээ XX зууны Монголын түүхийн зангилаа асуудлуудын нэг “баруунтан”, “зүүнтэн”-ий тэмцлийг өдөөсөн Коминтерны тогтоол, түүнтэй холбогдуулж МАХН-ын байр суурь ямар байсан талаар өгүүллээ.

Түлхүүр үг: М.Амагаев, Ц.Дамбадорж, Г.Гэлэгсэнгэ, Б.Дугаржав, Коминтерн, Коминтерны тогтоол, МАХН, лам нар, ерөнхий илтгэл, Залуучуудын эвлэл

Коминтерн болон МАХН-ын харилцааны түүхэн дэх олон зангилаа асуудлын дотроос 1927 онд Коминтернээс Монголын талаар гаргасан нэгэн тогтоолын талаар энэхүү өгүүлэлтээ тогтож өгүүлье.

Уг тогтоол гарахаас өмнө МАХН болон Коминтерны харилцаа зарчмын асуудал дээр хурц маргаангүй хэвийн тайван байсан гэхэд болно. Энэ байдлыг таслахад хүргэж, Коминтерны довтолгоо идэвхжүүлэхэд М.Амагаевын 1926 оны сүүлээр Коминтернд тавьсан илтгэл гол нөлөө үзүүлсэн юм. Учир нь түүний илтгэлд үндэслэн Коминтернээс Монголын талаар тогтоол гаргасан нь бодит амьдралаас нэн хол, хүлээн авах боломжгүй зүйлүүд тусгагдсан байлаа.

Ялангуяа, Монголын лам нарыг нийгмийн гол дайсан мэтээр үзэж, тэдний эсрэг элдэв зүйлийг чиглүүлэхийн хамт тухайн үеийн намын удирдлагын баримталж буй улс төр, эдийн засгийн бодлого, “баяжигтун” лоозунгийн талаар болон нармай Монголын талаарх байр суурь, Японы консулд виз олгосон зэрэг явдлыг хатуухан буруушаасан нь дэндүү эрээ цээргүй авирласан өнгө аястай байв.

Тогтоолын агуулга нь бүхэлдээ Монголын үндэсний онцлогийг харгалзалгүй шууд зааварласан, тулгасан шинжтэй тул Монголын удирдлага түүнийг хэлэлцээд хүлээн авах боломжгүй хэмээн шүүмжлэлтэй хандаж, дур мэдэн намын өмнөөс илтгэл тавьсан М.Амагаевыг буруушаасан шийдвэрийг гаргажээ.

Энэ нь үндэсний ардчилсан үзэлтэнүүд үзэл бодлын хувьд төлөвшилийг олсоныг харуулаад зогсохгүй өөрсдийн байр суурийг зарчмын асуудал дээр цаг тухайд нь хамгаалсан, улс төрийн бие даасан зоримог шийдвэр байсныг хэлэх хэрэгтэй.

Хэдийгээр зүй ёсны хэрэг байтал Коминтерн ихээхэн дургүйцэлтэй хандсан бөгөөд үүнээс улбаалан намын удирдлагыг Холбоот Улсаас салж холдох хэмээсэн мэтээр үзэж хэвийн бус байдлыг үүсгэн өдөөх болсон нь цаашдын хоорондын харилцаанд сөргөөр нөлөөлсөн юм.

Коминтерны тогтоол гарч хоёр талын хэвийн харилцаа хурцдаж, хүйтрэх болсон нь Коминтерны төлөөлөгчөөр ажиллаж байсан М.Амагаевын илтгэлтэй шууд холбоотой бөгөөд Монголын удирдлагуудтай зарчмын асуудал дээр зөрчилдөн зарим талаар хүчрэхгүй болсоны дээр тэдний тааламжгүй харилцаа нь улам бүр хүйтрэн алхам тутам зөрчилдүүлэх шалтгааны үндэс болж, ан гарсан үл ойлголцолд ихээхэн нөлөөлдөг байжээ.

Мөн нөгөө талаар М.Амагаевын зан төлөв үүнд багагүй нэрмээс болж сэдэл төрүүлж, өдөөж байсныг хэлэх хэрэгтэй.

III МОНГОЛЫН ОЙРХИ ТҮҮХИЙН АСУУДЛУУД

МАХН-ын дэргэд Коминтернээс суугаа төлөөлөгч М.Амагаев КИГХ –ны АДНБДНГ-т илтгэлийг тавьж, мэдээлэл хийхдээ намын удирдлагын явуулж буй гадаад, дотоод бодлого, Монгол орны хөгжлийн талаарх тэдний байр суурь, төлөвийн талаар илтгэжээ.

М.Амагаевын илтгэлтэй холбогдуулан КИГХ-ны АДНБДНГ-аас 1927 оны нэгдүгээр сарын 8-нд тогтоол гаргаж, МАХН-ын Төв Хороонд өгөх удирдамж боловсруулах комиссыг Васильев, Петров, Абугов, Амагаев нарын бүрэлдэхүүнтэй баталжээ.

Мөн энэ хурлаар Коминтерны Монгол дахь төлөөлөгчийн албанаас чөлөөлөгдөхийг хүссэн М.Амагаевын хүсэлтийг хэлэлцээд АДНБДНГ-аас зөвшөөрсөн хэдий ч түүний орны хүнийг томилогдох хүртэл хэдэн сар Монголд ажиллахыг хүссэн байдаг.¹

Үүнээс харахад М.Амагаев нь цаашдаа Монголд ажиллах сонирхолгүй байсан тул илтгэл, мэдээлэлээ зориуд хурцаар тавьсан төдийгүй нөгөө талаар Монголчуудын дунд нэр хүнд унаж ажиллах боломжгүйн улмаас албанаас чөлөөлөхийг хүссэн бололтой.

Уг тогтоолыг М.Амагаев өөрийн биеэр намын удирдлагад авчирч өгсөн ба МАХН-ын удирдлага Коминтернээс гаргасан тогтоолд өөрийн байр суурийг илэрхийлэн тусгай төлөөлөгч одуулахаар болсон байдаг.

Коминтерны тогтоолын орос эх машиндсан арван нэгэн хуудас бөгөөд найман хэсгээс бүрддэг ажээ. Тогтоолд, Монголын лам нарыг “хувьсгалын эсэргүүцүүдтэй холбоо тогтоох найдваргүй этгээдүүд” хэмээн шууд онцлон заасан бөгөөд “лам нарын нийгмийн саланги байдлыг хоромхон ч хэтрүүлэн үнэлж болохгүй. Харин ч лам нар бол хүн амын шашин шүтлэг бүхий олон түмэнд асар их нөлөө, жинтэй бөгөөд олон зуунаар бэхжин тогтсон чадамгай байгууллагатай тусгайлан сургуулилан бэлтгэгдсэн ухуулгын бүхэл армитай улс төрийн хүчин мөнийг нам мартаж өсгүй.

Лам нар болбоос нам ба ардын хувьсгалт засагт дур санал эсэргүү бөгөөд ойшоохгүй явдал буй нь өмнө зүгийн улс төр буюу хувьсгалын явдлын төлөв байдал өөрт тохирох цагийг тохиолдуулан Хятадын цэргийн хүчин түрэмгийлэгчдийн анги... Японы эзэрхэг түрэмгий нар лугаа холбоо тогтоож ч магад. Иймд шар харгисын этгээдээс дахин хөдлөх нь болзошгүй учраас нам нь ... юуны урьд лам нарын хэрэгт зарчмын нягт бодлогыг тогтоох нь сүүлийн үед чухал.

... Богдын тухай бас шинэ хутагт хувилгаадыг өргөмжлөх ба дацан хийдийн жас жавын малаас албан татварыг хураах, улсын сангаас шашны мөргөлийн явдалд хөрөнгө нэмэрлэх зэрэг асуудлаар үүний урьд нэгэнт тогтсон зүйлийг хэрхэвч өөрчлөхгүйгээр явуулбал зохино”² хэмээжээ.

Уг тогтоолд дурдагдсан “дахин хөдлөх нь болзошгүй учраа” хэмээн онцлогдсон зүйл бол 1926 онд Хан Хэнтий уул аймгийн Баянтүмэний хүрээний лам нарын эсэргүүцлийг хэлжээ.

Баянтүмэн уулын хошууны хүрээний хэдэн зуун лам нар жас жавын малаас албан тавар төлүүлэхийг эсэргүүцэн харъяат тамгын газар жагсан эсэргүүцэл үзүүлсэн юм. Уг хэргийг Намын Төв Хороо, Засгийн газраас томилсон комисс газар дээр нь очиж таслан уг хэргийг толгойлсон цоохор Ишжамц, зогсоо хэмээх Молом нарыг цаазлан бусдыг нь гянданд хорих, торгох, донгодох зэргээр таслан зогсоосон байдаг.

Намын Төв Хороо, Засгийн газраас томилогдсон комисс намын Ү их хурал дээр уг асуудлын талаар дэлгэрэнгүй илтгэл тавьсан³ байх ба илтгэлтэй холбогдуулан гаргасан тогтоолд дээрх комиссын ажлыг бүхэлд нь сайшааж, “...таслан шийтгэсэн нь үнэхээрийн зүйтэй болсон ба харин өршөөлийг үзүүлэх хөнгөвчлөн шийтгэснээс бус хүндээр аваачсан гэж үл

¹ РГАСПИ, Ф.495, оп 154, д. 237, л. 5

² РЦХИДНИ, Ф.495, оп 2, д.70, л.158-159

³ МАХН-ын Ү их хурал, УБ., 1926 он 115-116 дах тал

III МОНГОЛЫН ОЙРХИ ТҮҮХИЙН АСУУДЛУУД

МОНГОЛЫН ОЙРХИ ТҮҮХИЙН АСУУДЛУУД

МОНГОЛЫН ОЙРХИ ТҮҮХИЙН АСУУДЛУУД

МОНГОЛЫН ОЙРХИ ТҮҮХИЙН АСУУДЛУУД

МОНГОЛЫН ОЙРХИ ТҮҮХИЙН АСУУДЛУУД

МОНГОЛЫН ОЙРХИ ТҮҮХИЙН АСУУДЛУУД

МОНГОЛЫН ОЙРХИ ТҮҮХИЙН АСУУДЛУУД

МОНГОЛЫН ОЙРХИ ТҮҮХИЙН АСУУДЛУУД

МОНГОЛЫН ОЙРХИ ТҮҮХИЙН АСУУДЛУУД

МОНГОЛЫН ОЙРХИ ТҮҮХИЙН АСУУДЛУУД

МОНГОЛЫН ОЙРХИ ТҮҮХИЙН АСУУДЛУУД

МОНГОЛЫН ОЙРХИ ТҮҮХИЙН АСУУДЛУУД

МОНГОЛЫН ОЙРХИ ТҮҮХИЙН АСУУДЛУУД

МОНГОЛЫН ОЙРХИ ТҮҮХИЙН АСУУДЛУУД

МОНГОЛЫН ОЙРХИ ТҮҮХИЙН АСУУДЛУУД

МОНГОЛЫН ОЙРХИ ТҮҮХИЙН АСУУДЛУУД

МОНГОЛЫН ОЙРХИ ТҮҮХИЙН АСУУДЛУУД

Хэдхэн сарын дараа Ц.Дамбадоржээс "Ф.Ф.Гилевичийн "Монголын асуудлаар КИГХ-ноос гаргасан сүүдрийн хэлэлцээний хандсан хандлага нь Коминтернээс холцсон гэж зэмлэх үндэслэлгүй" гэж түүний тогтоолын зарим томъёололтой бичигээр нийтэлдэг үзэл мэдэгдсэн. Гэлгээснэгэ, Дугаржав насаар явуулсан хэлэлцээний үр дүнг нийцэхгүй зүйл л тэр байгаа юм"¹⁹ хэмээнэв. Үүнийг үзэхэд түүний тайлбарыг Ц.Дамбадорж, бичиж намын удирдлагад өгсөн

Зургаан зүйлт тайлбарыг ороо хэлтгэл хэрэгсэлтэйгээр хийх үйл ажиллагааны ерөнхий илтгэлийг авч үзвэл, 1990-аараах үйл ажиллагаа явуулахад бусад улсын хувьсгалын явдалд үндэсн хэрэгсэлтэйгээр нийтэд Монголын байдлыг харгалзан төрөлөөр, байрлалаар, үйлдвэр хөдөлгөхгүй явдал тун ч үлэмж тус тусын хувьд үйлдвэр хөдөлгөөн чадлын хэрээр хэрэгт тус болж, бусдын түрэмэг, үйлдвэр хөдөлгөөн төдийгөөр тус хорооны гишүүдийн аюулд хүлээх хэрэгсэлтэйгээр

... Лам нарын тухай явуулсан бодлого, үндэсний бодлого, уул бодлого зорилгыг явуулахад машаагүй их ажиллагаа хичээсээр буй.

Нам ба засгийн ажлын үр дүнг хүндэтгэн үнэмлэх баримт бичгээр ардаас татаж зүтгүүлэхийг тус тусад нь захиарх үүрэгтэй. Үүнийг гүйцэтгэх хүмүүс олддохгүй хэдийг үгүйсгэж, өөрсдийн хамт олгох засгийн албан хэрэгт зүтгүүлэн, тус тусад нь захиарх үүрэгтэй.

Манай монголчууд дургачууд чингидэггүй. Манай монголчууд дургачууд чингидэггүй.

тулгардах, дутагдах явдал байхгүй. Манай монголчууд тулгардах, дутагдах явдал байхгүй.

улсаас урихыг чуухал болгосон амуй. Манай монголчууд улсаас урихыг чуухал болгосон амуй.

Нагарт... Манай монголчууд нагарт...

...Нэгэнт хүрэлцэн ирсэн буудалчид сайнгүй, дотор зуураа тэмцэлдэх, буудалчид хэмжээнээс хэтгэрч учиргүй дур бодол төлөх, ташаа ташаагаар ховлох... аар саар аж ахуйн хэргийг баталсан гэрээ зүйлийг зориггоор зарлаж дан аар хязгаараас гаргах нэгэнт бэлтгэх гүйцэтгэхэр ажлын зэргийн явдал үлэмж. Олон монголчуудыг үнэмлэх завсардаж үг өгүүллийн үндэс болжээ. Хуучинт гадуурхаж битүү эсэргүүцсэн зүйл үгүй.

Ийнхүү ардын нам, төрийн удирдлагын зөвлөх, хөгжлийн үндэсний ардчилсан үндэсний бодлогын төлөөлөгч, өвөрмөц онцлогт тохирсон бодлого явуулахын зорилготой бус Дамбадорж тэргүүний нэхлэг Космийн тусламж, хөндийрөх гэсэн хэрэгт огтхон ч биш байгаа.

⁹ Коминтерн ба Монгол, УБ..., 1996: 186-тала.

¹⁰ МАХН-ын Төв архив, Ф.4, д.2, хн. 229, 4-8 дугаар тал.

¹¹ О.Батсайхан, Монгол улсын хөгжлийн замд 3 чигрсэн хүүхдүүд, 2010.

болно. Хэрэв энэ мэт хэрэг дахин гарч ирэх аваас даруйд хувь зэрэг нэмэгдүүлэн хууль цаазны ёсоор хүндэд чангалан цээрлүүлэн устгана”⁴ хэмээжээ.

Мөн 1926 онд Цэцэрлэг мандал аймгийн Намнан уулын хошууны хүрээнд шашны захиргаа байгуулахыг эсэргүүцсэн лам нарын үймээн бас гарчээ.

Коминтерн, Монголын лам нараас үнэнхүү цэрвэхийн хамтаар ангийнх нь хувьд устгах бодлого барьж байлаа. Тиймээс ч ардын намын бодлогод шүүмжлэлтэй хандан, эрх ашигт хөндөгдөн хязгаарлагдахыг үл тэвчсэн лам нарын эсэргүүцлийг үүгээр шалтаглан бүхэлд нь дарж авах сонирхол байлаа.

Нэгэнт МАХН-д Коминтерноос 1927 оны нэгдүгээр сарын 17-ноор өдөрлөсөн тогтоол ирсэн учраас МАХН-ын Төв Хорооны Тэргүүлэгчдийн 1927 оны YI их хурлын тогтоолд, “Энэхүү нөхөр Амгаагийн илтгэл ба Коминтернаас гаргасан Монголын тухай тогтоолыг сонсов. Үүний дотроос зарим зүйлд үнэн учрыг тайлах хариу сонсгон илтгэл зохих тул эл тайлбарлан илтгэх зүйлийг тус хорооноос төлөвлөн гүйцэтгүүлэхээр тогтоов” гэсний дагуу зургаан зүйл бүхий хариу тайлбарыг боловсруулсан байна.

Коминтернд явуулсан тайлбарыг МАХН-ын Төв Хорооны Тэргүүлэгчдийн 1927 оны дөрөвдүгээр сарын 5-ны өдрийн 9 дүгээр хурлаар хэлэлцэн засамжлаад баталжээ.⁵

Дээрх тайлбарын зургаадугаарыг ХБТК-ын саналын дагуу дахин засамжлан тэргүүлэгчдийн 10-р хурлаар бүгд гар өргөн баталжээ.⁶

Коминтернд илгээх тайлбарын зургаадугаар зүйлд Японы консулын Монголд ирүүлэх зөвшөөрөл өгсөн талаар дараах зүйлийг бичжээ. Үүнд, “Манай Монгол улсын үндсэн хуульд намын гадаад лугаа харилцах товч бодлого тодорхой боловч манай Төв Хорооноос аливаа гадаадын улс лугаа холбогдох хэргийн учир маш болгоомжлон шийтгэсээр ирсэн бөгөөд Японы консулын тухай нэгэн адил Холбоот улсын гадаад яамнаас үл татгалзах хэмээв хэмээн ирснийг баримтлан тийнхүү тогтоосон бөлгөө. Тухайд үл татгалзах саналыг Холбоот улсын гадаад яамнаас ирүүлэхэд Японы дорно орноо явуулан бүхий харгис шунахай бодлогыг урьдаас хянаж мэдсэн хэрэг буй за хэмээн бодно”⁷ гэсэн тайлбарыг оруулжээ.

Коминтернд хариу тайлбар өгөхөөр одох төлөөлөгчөөр анх Ц.Дамбадорж, П.Гэндэн нарыг томилсон авч Намын Төв Хорооны Тэргүүлэгчдийн тавдугаар сарын 9-ний хуралдаанаас Г.Гэлэгсэнгэ, Б.Дугаржав нарыг томилжээ.⁸

Г.Гэлэгсэнгэ, Б.Дугаржав нарыг КИГХ-ны YIII бүгд хуралд оролцуулах МАХН-ын төлөөлөгчөөр томилсон ба улмаар КИГХ-ны АДНБДНГ-т илтгэл тавьж, Коминтерны тогтоолд МАХН-аас хариу тайлбар хийх үүрэг өгсөн байна.

Тайлбар хийх төлөөлөгчдийг сольсон шийдвэр нь Коминтерны төлөөлөгч М.Амагаевын санал, нөлөө юу? эсвэл намын дарга Ц.Дамбадоржийн санал байв уу? гэдэг нь тодорхой биш байгаа юм. Хэнийх нь ч санал байлаа гэхэд М.Амагаевын хувьд Ц.Дамбадоржийг Москвад ирүүлэхгүй байх, харин Ц.Дамбадоржийн хувьд Коминтернийг өөрийгөө өмөөрсөн хувийн шинжтэй тайлбар хэмээн ойлголт өгөх вий хэмээн болгоомжилсон байж болох.

Харин тогтоолтой холбогдуулсан МАХН-ын тайлбарыг Ц.Дамбадорж бичсэн байх ба үүнийг дараах баримт нотлох юм.

⁴ МАХН-ын Y их хурлын дэлгэрэнгүй тайлан, УБ., 1981, 248-249 дэх тал

⁵ МАХН-ын Төв архив, ф.1, д.4, хн. 8, 56-60 дах тал

⁶ Мөн тэнд., ф.1, д.4, хн. 8, 56-60 дах тал

⁷ Коминтерн ба Монгол, УБ., 1996, 139 дэх тал

⁸ МАХН-ын Төв архив, ф.1, д.34, хн. 8, 80 дах тал

III МОНГОЛЫН ОЙРХИ ТҮҮХИЙН АСУУДЛУУД

Хэдхэн сарын дараа Ц.Дамбадоржоос Ф.Ф.Петровт бичсэн хувийн захидалдаа, “Монголын асуудлаар КИГХ-ноос гаргасан сүүлчийн тогтоолд миний (Ц.Дамбадорж Д.Д) хандсан хандлага нь Коминтернээс холдсон гэж зэмлэх үндэс болсон гэж бодож байна. КИГХ-ны тогтоолын зарим томъёололтой би санал нийлэхгүй байгаа, энэ тухай би Төв Хороонд ч мэдэгдсэн. Гэлэгсэнгэ, Дугаржав нараар явуулсан захидлын эхийг би бичсэн юм. Миний санал нийцэхгүй зүйл л тэр байгаа юм”⁹ хэмээжээ. Үүнээс үзэхэд Коминтернд явуулсан тогтоолын тайлбарыг Ц.Дамбадорж, бичиж намын удирдлага ч бүхэлдээ дэмжсэн байна.

Зургаан зүйлт тайлбарыг орос хэл дээр хөрвүүлэн гарын үсгээ зурсан байх ба мөн намын үйл ажиллагааны ерөнхий илтгэлийг авч явжээ. Илтгэлийн гол агуулга нь “хувьсгалын үйлийг явуулахад бусад улсын хувьсгалын явдлаас үндсэн зам аргыг үлгэр үзэмж болгон авсаар боловч нийтэд Монголын байдлыг харгалзаж эргэлзэх, болгоомжлох алгуур түргэн хөдөлгөх, хөдөлгөхгүй явдал тун ч үлэмж тул хэлэлцэх, шүүмжлэхэд харъяат гишүүд өөр өөрийн чинээ чадлын хэрээр хэрэгт тус болох саналыг гаргахад харилцан зөрөлдөх зүйл хааяа гарсан төдийгөөр тус хорооны гишүүдийн дотор олонхи, цөөнх хэмээн үзэх явдалгүй болов уу.

... Лам нарын тухай явуулсан бодлогыг өөрчлөх буюу ухрах сэдэв огтхон ч үгүй бөгөөд уул бодлого зорилгыг явуулахад маш болгоомжлон үндэсний хувьсгалын хэрэгт хор болгохгүйг хичээсээр буй.

Нам ба засгийн ажилд оролцон бүхий шударгагүй этгээдийг зайлуулан жинхэнэ шударга ардаас татаж зүтгүүлэхийг тус намаас ямагт шөнө бүрийн бодлого болгосоор нь тэр бүх чадах тэнцэх хүмүүс олдохгүй хэдий тийн хэмээвч төв ба орон нутгийн газраа олдсон хэрээр нам засгийн албан хэрэгт зүтгүүлэн улмаар өрнүүлэхийг хичээж буй.

...Холбоот улсын сургагч нарын гадуурхах, өөдөлшгүй этгээдийг дотлоон хэрэглэв хэмээн иржээ.

Манай монголчууд сургагчгүйгээр хөгжүүлэн гүйцэтгэж үл чадах хэрэг маш үлэмж ба тулгардах, дутагдах явдал байхын учраа сургагчийг хэрэглэсэн бөгөөд юуны урьд Холбоот улсаас урихыг чухал болгосон амуй.

...Нэгэнт хүрэлцэн ирсэн сургагч нарын зарим нь аливаа ажилд идэвх оролдлого сайнгүй, дотор зуураа тэмцэлдэх, булаалдах анги бүлэг болох зарим нь хэргийг явуулахад эрх хэмжээнээс хэтэрч учиргүй дур мэдэж барих, тавих ажилд зүтгэл бүхий гэмгүй хүмүүсийг худал ташаагаар ховлох... аар саар аж ахуйн хэрэгт хоршин хамтрах хэмээн шаардах, нэгэнт баталсан гэрээ зүйлийг зоригоор зарлаж дангаар устгах, хэлэлцэн тогтоосон хүнийг барьж хязгаараас гаргах нэгэнт бэлтгэх гүйцэтгэхээр ажлыг хүлээсэн атал хэдэн жилээр үл гүйцэтгэх зэргийн явдал үлэмж. Олон монголчуудаас үүнийг эсэргүүцэх үл хүлээх болбоос харилцан завсардаж үг өгүүллийн үндэс болжээ. Холбоот улсын сургагч нарыг монголчлох хэмээх нэрээр гадуурхаж битүү эсэргүүцсэн зүйл үгүй”¹⁰ гэжээ.

Ийнхүү ардын нам, төрийн удирдлагаар өөрийн бодлогоо тайлбарласан нь Монголын хөгжлийн үндэсний ардчилсан чиг баримтлалаас үүдэж, ард олны эрх ашигт нийцсэн улс орны өвөрмөц онцлогт тохирсон бодлого явуулахыг эрмэлзэж ирснээ илэрхийлсэн хэрэг болохоос бус Дамбадорж тэргүүний нөхөд Коминтерний засвар тогтоолыг эсэргүүцэж, түүнээс хөндийрөх гэсэн хэрэг огтхон ч биш байлаа”¹¹ хэмээн тайлбарлажээ.

⁹ Коминтерн ба Монгол, УБ., 1996 186 тал

¹⁰ МАХН-ын Төв архив, Ф.4, д.2, хн. 229, 4-8 дах тал

¹¹ О.Батсайхан, Монгол улсын хөгжлийн замд учирсан ээдрээ (1921-1932) УБ., 1997, 48 дах тал

Коминтерны тогтоолд өгөх МАХН-ын хариу гайлбарыг Б.Дугаржав, Г.Гэлэгсэнгэ нар Коминтернд тавдугаар сарын 24-нд өгсөн ¹² ба КИГХ-ны АДНБДНГ тавдугаар сарын 28 болон 31, зургадугаар сарын 1-ний өдрүүдэд тус, тус хэлэлцжээ.

Дээрх хуралдаануудад Петров Ф.Ф., Райт В.Н., Очиров*, Абугов нар тогтмол оролцсон байх ба Шумяцкий Б.З., Васильев Б.А., М.Амагаев, Рейнштейн, Каспаров, Файнберг нар зарим өдрийн хуралдаанд оролцож байжээ.

КИГХ-ны Дорнодын хэлтсийн эрхлэгч Петров.Ф.Ф (1892-1939)-оос Сталин.И.В., Бухарин.Н.И нарт МАХН-ны Төв Хорооны төлөөлөгчдийн талаар товч магадлагааг гарган тавдугаар сарын 18-нд хүргүүлсэн байдаг.

Уг тодорхойлолтонд, Г.Гэлэгсэнгийн талаар “МАХН-ын Төв Хорооны нарийн бичгийн дарга, Дамбадоржийн баруун гар, Төв Хорооны гуравдугаар сарын бүгд хурлын өмнө болон бүгд хурал дээр Дамбадоржийн чиг шугамыг бүрэн дэмжиж байсан. Төв Хорооны санхүүгийн бүх ажил хэргийг эрхэлдэг Төв Хорооны нилээд хэдэн гишүүн, тэр дундаа Дамба (Ц.Дамбадорж Д.Д)-д хүчтэй нөлөөлдөг” гэжээ.

Б.Дугаржавыг МАХН-ын Төв Хорооны гишүүн, Төв Хорооны суртал ухуулгын эрхлэгч, буриад, оросоор сайн ярьдаг. Буриад хүн болохоор Төв Хорооны гишүүн халх монголчуудын дургүйг хүргэхвий гэж айгаад Төв Хороонд өөртөө итгэл муутай байдаг, Зөвлөлтийн ажилтан нартай ярилцахдаа хаягаа манаж хаширлаад байдаг Дамбадоржийг мөн зарим талаар Гэлэгсэнгээг чиг баримжаа болгон дагалддаг. Төв Хорооны удирдах бүлэг түүнд голдуу намын их хурлын илтгэл бэлтгэх, оросуудын хурал дээр Төв Хорооны өмнөөс баяр хүргэж үг хэлэх мэтийг даалгаж гүйцэтгүүлдэг.

Гойд их нэр хүндгүй боловч Төв Хорооны удирдах хүмүүс түүнд тогтоол, шийдвэр, санал зэргийг боловсруулж бэлтгэх даалгавар өгдөг байна. Намын хэвлэлийн ажлыг удирддаг. “Үнэн” сонины эрхлэгч Навааннамжил, Дугаржавын нөлөөнд байдаг байна ¹³ гээд МАХН-ын төлөөлөгч Гэлэгсэнгэ, Дугаржав нар Сталинтай уулзахыг хүсэх бодолтой байгааг уламжилжээ. Гэвч МАХН-ын төлөөлөгчид И.В.Сталинтай уулзсан эсэх нь тодорхойгүй бөгөөд хараахан баримтыг олж үзээгүй байгаа юм. Магад уулзаагүй бололтой.

Г.Гэлэгсэнгэ, Б.Дугаржавын илтгэлтэй холбогдуулан МАХН-ын Төв Хороонд Коминтерны төлөөлөгчөөр сууж байсан М.Амагаев, КИГХ-нд дүгнэлт гарган өгсөн байдаг. Түүний гаргасан дүгнэлтэнд, МАХН-ын ерөнхий илтгэл хоёр зүйлээс өөр онцгой гойд зүйлийг агуулаагүй байна гэж үзжээ. Түүний үзсэнээр, нам дах хөдөөгийнхэн ба хотынхон, залуу ба хөгшин гэх нөгөө нь нам ба хувьсгалт залуучуудын эвлэлийн харилцааны тухай асуудал байжээ.

Нэг дэх зүйл нь нам дах хөдөөгийнхэн ба хотынхон, залуу ба хөгшин хэмээгчдийн тухай асуудалыг хөндөж байгаа юм гээд, уг асуудал нь анх Төв Хорооны II бүгд хурал дээр гарсан бөгөөд хурлын тогтоолд намын хүч чадлыг бэхжүүлэхэд хортой хэвийн бус ангилалыг цаашдаа орхивол зохино. Тийм үзэгдэл гарсан тохиолдолд буруутныг намын сахилгын дагуу цээрлүүлбэл зохино. Баруун бүлэг Төв Хорооны энэ тогтоолыг тийнхүү дэлгэрэнгүй тайлбарлах нь хортой бөгөөд алдаатай болохыг МАХН-ын төв Хороонд зааж өгөх ёстой.

Хоёрдах зүйл нь нам ба хувьсгалт залуучуудын эвлэлийн харилцааны тухай өгүүлжээ. Намаас залуучуудын эвлэлийн үзэл сурталын талаар удирдахын тулд хувьсгалт залуучуудын эвлэлийн хороодын дэргэд намын комиссаруудыг ажиллуулах онцгой журам тогтоох хэрэгтэй

¹² РГАСПИ, ф.495, оп 152, д.48, л.88-92

¹³ УТА, сх.445, д.5, хн 50, 1-2 дах тал

* Оширов ч гэж бичигдсэн байдаг.(Д.Д.)

болж байна. Энэ нь баруун бүлэг залуучуудын эвлэлийг атгандаа бүрэн оруулах оролдлого юм. Ийнхүү байдлаар дэвшүүлэн буйг эсэргүүцэх ёстой.

МАХН-ын Төв хороо хөдөөгийнхэнийг идэвхтэй дэвшүүлэх талаар хангалтгүй ажиллаа гэсэн сэжиг таавар цухалзаж байна. Иймэрхүү булзаарлын улс төрийн далд зорилго бол нэгдүгээр сарын тогтоолоос уг зүйлсийг хасуулах, улмаар... дэвшүүлж ажиллуулахуйц эрчимтэй, шударга, жинхэнэ ард ховор гэдгээр шалтаг заахад оршиж байна. КИГХ-ны АДНБДНГ тогтоолын энэ зүйл байх ёстой гэдгийг эрс шууд заах хэрэгтэй болж байна гээд өөрийн саналуудыг бичжээ. Үүнд,

1. Дугаржав, Гэлэгсэнгэ нарын илтгэлийн талаар нөхцөл байдлыг шинжилж, намын ажилд үнэлэлт дүгнэлт өгсөн тусгай тогтоол гаргахгүй байх

2. Нэгдүгээр сарын тогтоолыг үндсэнд нь дахин нотлох

3. Ажил хэргийг улам их холбохын тулд КИГХ-ын АДНБДНГ-т МАХН-ын Төв Хороо 3 сар тутам мэдээлэлийн захидал тогтмол илгээх, улс төрийн байдал болон намын ажлын тухай МАХН-ын Төв Хороо ба Коминтерны төлөөлөгчтэй хамтарсан илтгэлийг жил тутам илгээж байх, намын ҮИ их хуралд Коминтерны тусгай төлөөлөгч илгээх санал тавьсан байдаг.¹⁴

КИГХ-оос Г.Гэлэгсэнгэ, Б.Дугаржав нарын тавьсан МАХН-ын ерөнхий илтгэл болон тогтоолд өгсөн тайлбарыг танилцаад дахин тогтоол болгон баталсангүй харин КИГХ-ны АДНБДНГ-аас Намын Төв Хороонд илгээж буй захидал маягаар өгөхдөө өмнөх санаагаа баталгаажуулжээ. Энэ захидалыг КИГХ-ны АДНБДНГ-ын 1927 оны зургадугаар сарын 1-ны хуралдаанаас Гэлэгсэнгэ, Райт, Абугов нарын бүрэлдэхүүнтэй байгуулсан комисс¹⁵ боловсруулж, мөн сарын 8-ны өдөр КИГХ-ны улс төрийн нарийн бичгийн дарга нарын газар баталжээ.

Уг захидалд, “КИГХ-ны АДНБДНГ Гэлэгсэнгэ, Дугаржав нарын илтгэлийг сонсоод хувьсгалт намын үйл ажиллагааг сайшаав. КИГХ-оос Монголын асуудлаар гаргасан нэгдүгээр сарын тогтоолд заагдсан зорилтууд нь Гадаад монголын Ардын хувьсгалт намын өмнө үндсэндээ ойрын үед баримтлах зорилтууд хэвээр үлдэнэ гэж АДНБДНГ үзэж байна. Лам нарын асуудлын талаар МАХН-ын Төв Хороо нэгдмэл нэг санал байхгүй байна, ямар ч буулт хийхгүй байхыг л КИГХ-оос сануулан болгоомжлуулж байна.

Хувьсгалт залуучуудын эвлэлээс Монгол орны нам, төр, олон нийтийн ажилд идэвхтэй оролцох явдлыг сайжруулах нь чухал байна гээд КИГХ-ны АДНБДНГ-т мэдээлэлийн захидалыг аль болох тогтмол ирүүлэх, намын ажлын тухай ба улс төрийн байдлын тухай МАХН-ын Төв Хорооны төлөөлөгч ба хамтарсан илтгэлийг зургаан сар тутам тавиулж байхыг хүсч байна”¹⁶ гэжээ.

МАХН-ын ерөнхий илтгэл, тогтоолд өгсөн хариу тайлбарт Коминтернээс өгсөн захидалд М.Амагаевын санаа үндсэндээ тусгагдсан бөгөөд үүнээс хойшхи МАХН-ын болон Коминтерны харилцаа ихээхэн хурцдах болсон билээ.

¹⁴ РГАСПИ, ф 495, оп.152, д.53, л35-41

¹⁵ Мөн тэнд ф.495, оп. 154, д.287, л.59

¹⁶ РГАСПИ, ф 495, оп. 154, д.287

Abstract

Among various critical issues in the history of relations between Comintern and the MPRP, there is a resolution on Mongolia issued by Comintern in 1927, about which I wrote in my article.

The main influence in issuing this resolution that boosted Comintern attacks on Mongolia was greatly influenced by the report made to Cominter by M. Amagayev in 1926. The content of the resolution was far from the Mongolian reality, was aimed against Buddhist lamas and disregarded national interests and national distinctions of the Mongols. It had a clear commanding attitude. That is why Mongolian leaders had a critic approach to the resolution, refused to accept it and, moreover, criticized M. Amagayev for delivering the report on behalf of the MPRP deliberately and without prior notice. This quite natural reaction by the Mongolian leadership caused rage within Comintern, followed by its accusation of MPRP leaders in an attempt to break away from the Soviet Union and Comintern. This chilled the relations between Mongolia and Comintern and lead to a number of serious controversies.